

# “ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 09-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

## Журам шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 2.9.8 дахь заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн нэмэлт ажлын үйлчилгээ зохицуулах журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Дээрхи журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэн ажиллахыг гүйцэтгэх захирал /Д.Балдорж/-д үүрэг болгосугай.

3. Нэмэлт ажил үйлчилгээний орлогыг холбогдох хууль, журмын дагуу төвлөрүүлж, зарлага гаргахдаа санхүүгийн зөрчилгүй ажиллахыг гүйцэтгэх захирал /Д.Балдорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Баярцэнгэл/ нарт үүрэг болгосугай.

4. Журмыг баталсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 01 сарын 23 өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан нэмэлт ажлын үйлчилгээний журмыг хүчингүйд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ДИСПЕТЧЕРИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА ҮНДЭСНИЙ ТӨВ Д.ЦИМЭДДОРЖ

